

Олгогдоогүй цалин хөлсийг нөхөн төлөх хөтөлбөрийн танилцуулга

I

Олгогдоогүй цалин хөлсийг нөхөн төлөх хөтөлбөрийн тухай

Тус хөтөлбөр нь ажилчид болон тэдний гэр бүлийн амьдралыг тогтвортой байлгах зорилгоор улсаас хэрэгжүүлж буй нийгмийн аюулгүй байдлын сүлжээ болно. Ажил олгогч нь дампуурсны улмаас цалин хөлсгүй ажлаас гарсан ажилчдын олгогдоогүй цалинг "Цалингийн төлбөрийг баталгаажуулах тухай" хуульд үндэслэн засгийн газрын зүгээс бизнес эрхлэгчийн өмнөөс тодорхой хэсгийг нөхөн төлдөг юм.

Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг (цаашид "агентлаг" гэх) энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ба нөхөн төлбөр хийхдээ ажилчны цалингийн нөхөн төлбөртэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнг тухайн ажилчныг төлөөлөн бизнес эрхлэгчээс нэхэмжилнэ.

II

Нөхөн төлбөр авах боломжтой хүмүүс

Нөхөн төлбөр авагч нь доорх нөхцөлүүдийг хангасан байх

- 1 "Ажилчдын гэнэтийн ослын нөхөн олговрын даатгал" (хөдөлмөрийн ослын даатгал)-д хамрагдах чиглэлээр 1 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа эрхэлсэн бизнес эрхлэгч (ААН, иргэн) дор ажиллаж байсан бөгөөд тухайн бизнес эрхлэгч дампуурсны улмаас цалин хөлсгүй ажлаас гарсан ажилчид (Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн 9-р зүйлд заасан ажилчид)
- 2 Шүүхэд дампуурлын бүртгэлийн хүсэлт гаргасан өдрөөс (хууль ёсны дампуурлын хувьд) эсвэл Хөдөлмөрийн стандартын хяналтын газрын даргад бодит хэрэг дээр дампуурч байгааг баталгаажуулах өргөдөл гаргасан өдрөөс (бодитоор дампуурсан бол) зургаан сарын өмнөх өдрөөс хойш хоёр жилийн хугацаанд тухайн компаниас гарсан хүн
Жич: Ажлаас гарснаас хойш 6 сарын дотор шүүхэд дампуурах өргөдөл, Хөдөлмөрийн стандартын хяналтын газрын даргад бодит дампуурлыг баталгаажуулах өргөдөл гаргаагүй бол нөхөн төлбөрт хамрагдахгүй.



- 3 Олгогдоогүй цалин хөлсний мөнгөн дүнгийн талаар дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тодорхойлолт (Хууль ёсны дампуурлын хувьд) эсвэл Хөдөлмөрийн стандартын хяналтын газрын даргын (Бодитоор дампуурсан бол) баталгаажуулалт хүлээн авсан хүн

I	Олгогдоогүй цалин хөлсийг нөхөн төлөх хөтөлбөрийн тухай
II	Нөхөн төлбөр авах боломжтой хүмүүс
III	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжийг хувиала
IV	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжийг хувиала
V	Нөхөн төлбөрдөх мөнгөн дүн
VI	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах бүрдүүлэлт
VII	Нөхөн төлбөр олгох
VIII	Шударга бусаар авсан бол
IX	Нөхөн төлбөрийг нэхэмжих
X	Төлбөрийн нэхэмжлэл, Ажилчид гаргах өргөдөл гаргах

Хөдөлмөрийн ослын даатгалд хамрагдсан бизнес

Хөдөлмөрийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай хуулийн заалтад хамрагдах бизнесийг хэлнэ. Хэрэв нэг буюу түүнээс дээш ажилчинтай бизнес бол хөдөө аж ахуй, ой, загас агнуурын аж үйлдвэрийн зарим салбараас бусад нь хамаарна. Мөн, хамт амьдардаг хамаатан садантайгаа ажилладаг бизнесүүд хамаарахгүй.

Ажилчид (Зөвхөн Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн 9-д заасан ажилчид)

Дампуурсан бизнес эрхлэгчийн дор ажиллаж, хөдөлмөрийн хөлс болгон цалин хөлс авч байсан хүнийг хэлнэ (цагийн ажил орно). Хамт амьдардаг хамаатан садны хувьд, хэдийгээр хамт амьдардаг хамаатан садан нь албан ёсоор ажлын байран дээр ажилчин хэлбэрээр ажилладаг ч ер нь тухайн бизнес эрхлэгчтэй нэг ашиг сонирхолтой, ижил байр суурьтай гэж үздэг тул зарчмын хувьд ажилчин гэж хүлээн зөвшөөрөхгүй.

Түүнчлэн, гэрийн хөдөлмөрийн тухай хуулийн дагуу гэртээ ажил эрхэлдэг гэх зэрэг гэрийн ажилчид хамрагдах боломжгүй юм. Үүнээс гадна компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтнууд хамрагдах боломжгүй.

Нөхөн төлбөрт хамрагдах дампуурлын төрөл

(1) Хууль ёсны дампуурал

Дампуурлыг бүртгэх шийдвэр (Дампуурлын тухай хууль), клирингийн тусгай журам эхлүүлэх тухай тушаал (Компанийн тухай хууль), дахин хөрөнгөжүүлэх тухай шийдвэр (Иргэнийг дахин хөрөнгөжүүлэх тухай хууль), дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа эхлүүлэх тухай шийдвэр (Компани дахин хөрөнгөжүүлэх тухай хууль)

(2) Бодитоор дампуурах (зөвхөн жижиг дунд бизнес эрхлэгчид)

Компани дампуурч бизнесийн үйл ажиллагаа нь зогссон, үйл ажиллагаа нь хэвийн үргэлжлэх горьдлого тасарсан ба Хөдөлмөрийн стандартын хяналтын газрын даргаас ажлын цалин хөлс төлөх чадваргүй болсныг гэрчилсэн.

А. “Бизнесийн үйл ажиллагаа нь зогссон” гэдэгт

Ажлын байр хаагдаж, бүх ажилчдыг ажлаас халсны улмаас уг бизнесийн үндсэн үйл ажиллагаа зогссон тохиолдлыг хэлнэ. Хэрэв зөвхөн үйл ажиллагааг зогсоох үүднээс шаардлагатай клирингийн үйл ажиллагааг явуулж байгаа бол энэ нь хамаарах боловч үйл ажиллагааны цар хүрээг багасгаж үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байвал энэ нь хамаарахгүй.

Б. “Үйл ажиллагаа нь хэвийн үргэлжлэх горьдлого тасарсан” гэдэгт

Ерөнхийдөө бизнес эрхлэгч нь бизнесээ сэргээх хүслээ орхисон эсвэл клирингийн үйл ажиллагаа эхэлж байгаа тул үргэлжлүүлэн ажиллуулах ямар ч найдваргүй тохиолдол.

В. “Ажлын цалин хөлс төлөх чадваргүй” гэдэгт

Ер нь бизнес эрхлэгчид цалин хөлс төлөхөд шаардлагатай хөрөнгөний эх үүсвэргүй гэсэн үг бөгөөд мөнгө зээлсэн ч цалин хөлсөө төлөх чадваргүй болсныг хэлнэ. Харин ерийн хэмжээ нь хөрөнгийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд, өөрөөр хэлбэл хэтэрсэн өр энд хамаарахгүй.


Мөн, жижиг дунд бизнес эрхлэгч гэж дараах аль нэгэнд хамаарах бизнес эрхлэгч байна.

	Өөрийн хөрөнгө болон хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	Үндсэн ажилчдын тоо
Аж үйлдвэрийн салбар (Бөөний худалдаа, үйлчилгээ, жижиглэнгийн худалдаа эрхлэхээс бусад)	300 сая иенээс доош ААН	300 хүнээс доош
Бөөний худалдааны салбар	100 сая иенээс доош ААН	100 хүнээс доош
Үйлчилгээний салбар	50 сая иенээс доош ААН	100 хүнээс доош
Жижиглэнгийн худалдааны салбар	50 сая иенээс доош ААН	50 хүнээс доош

III

Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжит хугацаа

Дампуурал буюу хууль ёсны дамбуурлын хувьд нөхөн төлбөрийг нэхэмжлэх боломжтой хугацаа нь шүүх дамбуурлын ажиллагаа эхлүүлэх шийдвэр гаргасан өдрийн маргаашаас хоёр жилийн дотор, бодит дамбуурлын хувьд Хөдөлмөр Стандарт хяналтын газрын дарга дамбуурлыг зарласны маргаашаас хойш хоёр жилийн доторх олгогдоогүй цалин хөлсийг нөхөн төлөх нэхэмжлэлийг агентлаг руу ирүүлэх ёстой. Хэрэв энэ хугацаа хэтэрсэн бол нөхөн төлбөр авах боломжгүй болно.



IV

Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжит хугацаа

Нөхөн төлбөрт хамрагдах олгогдоогүй цалин нь ажлаас гарсан өдрөөс 6 сарын өмнөх өдрөөс агентлаг руу хүсэлт гаргасан өдрийн өмнөх өдөр хүртэл хугацаанд төлөгдөх хугацаа нь болж байгаа "тогтмол цалин хөлс (*1)" ба "ажлаас гарсны тэтгэмж (*2)" байна. Харин, нийт цалингийн хэмжээ 20000 иенээс бага байх тохиолдолд энэ нь хамаарахгүй.

Цалин бодогдох өдөр: сар бүрийн 20-ны өдөр

Цалин олгох өдөр: тухайн сарын 26-ны өдөр



(Анхаар) 4-р сарын цалин (2020.03.21- 2020.04.12) нь өдрөөр тооцогдоно.

- I Олгогдоогүй цалин хөлсийг нөхөн төлөх хөдөлмөрийн тухай
- II Нөхөн төлбөр авах боломжийг хүмүүс
- III Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжийг хугацаа
- IV Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжийг хугацаа
- V Нөхөн төлбөртөлөгдөх мөнгөн дүн
- VI Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах бүрэлдүүлт
- VII Нөхөн төлбөр олгох
- VIII Шударга бусар аясын бол
- IX Нөхөн төлбөрийг нэхэмжлэх
- X Нөхөн төлбөрийн нэхэмжлэл (Ажлаас гарсан өдрийн өмнөх өдөр хүртэл төлөгдөх)

*1 Тогтмол цалин

Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан сард дор хаяж нэг удаа тогтмол төлдөг цалин хөлс (Жишээлбэл, үндсэн цалин, гэр бүлийн тэтгэмж, унааны тэтгэмж, илүү цагаар ажилласан нэмэлт тэтгэмж гэх мэт). Энэ нь орлогын албан татвар, оршин суугчдын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл гэх мэт хууль ёсны суутгалын дүнг хасахаас өмнөх дүн юм.

*2 Ажлаас гарсны тэтгэмж

Ажлаас гарсны тэтгэмж нь хөдөлмөрийн хамтын гэрээ, хөдөлмөрийн дүрэм (ажлаас гарсны тэтгэмжийн тухай журам) зэрэгт үндэслэн төлөгдөх ажлаас гарсны тэтгэмжийг хэлнэ. Бизнес эрхлэгч нь “Жижиг дунд бизнесийн ажлаас гарсны тэтгэмжийн сан” гэх мэтэд хамрагдсан ба тэрхүү хөтөлбөрөөс тэтгэмжийн мөнгө төлөгдөх бол тухайн мөнгөн дүнгээс хасаж үлдэгдэл мөнгийг нөхөн төлөх боломжтой.

*3 Өдрөөр цалинг тооцох

Сарын цалин (ажил тасалсан ч цалин хасагдахгүй бүтэн сарын цалинг оруулаад)-ы хувьд, ажлаас гарсан өдөр нь цалин бодогдох хугацааны дундуур байх тохиолдолд ажлаас гарсан өдөр хүртэл хугацааг өдрөөр тооцож цалинг бодно.

<Цалинг өдрөөр бодох аргачлал>

Хөдөлмөрийн дүрэмд заасан аргачлалаар бодох ба хэрэв дүрэмд тусгагдаагүй бол ажилласан өдрөөр тооцно.

“Өдрөөр тооцсон цалингийн дүн” = “Сарын цалин ба бусад нэмэгдэл цалин (албан тушаалын, гэр бүлийн, унааны г.м)” × “Ажилласан бодит хоног” ÷ “Календарын ажлын өдөр (календарын сараас шалтгаалан ажиллах хоногийн тоо өөр өөр бол жилд ажиллах хоногийг 12 сард хуваасан дундаж утгаар олсон ажлын өдөр)”

*4 Нөхөн төлбөрт үл хамаарах

Шагнал ба бусад түр цалин хөлс, ажлаас халагдсаны тэтгэмж, цалин хөлсний хугацаа хэтэрсэн хүү, жилийн эцсийн тохируулгад оруулсан татварын буцаан олголт, нэмэгдэл, халамжийн тэтгэмж нэрээр шагнах, аяллын зардал / хангамж гэх мэт зардлыг нөхөн төлбөрт хамаарахгүй.

*5 Олгогдоогүй цалингаас хасагдах зүйлс

Олгогдох ёстой тогтмол цалин ба ажлаас гарсны тэтгэмжээ авсан тохиолдол ба бизнес эрхлэгчид төлөх ёстой сар бүрийн байрны түрээс, компаниас худалдаж авсан барааны төлбөр, зээл, зээлийн эргэн төлөлт байгаа бол эдгээр төлбөрүүдийг хасаж тооцно.

Нөхөн төлөгдөх мөнгөн дүн нь нийт олгогдоогүй цалингийн 80 хувь байна. Харин, нөхөн төлөгдөх мөнгөн дүнд ажлаас гарсан өдрийн насанд тохирсон мөнгөн дүнгийн хязгаартай. Уг хязгаарыг давсан бол нөхөн төлөгдөх мөнгөн дүн нь мөнгөн дүнгийн хязгаарын 80 хувь байна.

Ажлаас гарсан өдрийн нас	Олгогдоогүй цалингийн дээд хязгаар	Нөхөн төлбөрийн дээд хязгаар
45-аас дээш	3,700,000 иен	2,960,000 иен
30-45 нас хүртэл	2,200,000 иен	1,760,000 иен
30 нас хүртэл	1,100,000 иен	880,000 иен

Жишээ 1: Ажлаас гарсан өдрийн нас 32, олгогдоогүй цалингийн нийт дүн 1,7 сая иен (тогтмол цалин 500,000 иен, ажлаас гарсны тэтгэмж 1,2 сая иен) байхад уг 1,7 сая иен нь 30-45 хүртэл насны хязгаар болох 2,2 сая иен дотор байгаа тул нөхөн төлбөрийн дүн = 1,7 сая × 0.8=1,36 сая иен болно.

Жишээ 2 Ажлаас гарсан өдрийн нас 48, олгогдоогүй цалингийн нийт дүн 4,7 сая иен (тогтмол цалин 1,5 сая иен, ажлаас гарсны тэтгэмж 3,2 сая иен) байхад уг 4,7 сая иен нь 45-аас дээш насны хязгаар болох 3,7 сая иенийг давсан тул нөхөн төлбөрийн дүн нь дээд хязгаар болох 2,96 сая иен болно.

“Хууль ёсны дампуурал” ба “Бодит дампуурал” байхаас шалтгаалан нэхэмжлэл гаргах аргачлал өөр байх тул анхаарна уу.


1 Хууль ёсны дампуурлын үед нэхэмжлэл гаргах журам

- (1) Нөхөн төлбөр нэхэмжлэгч нь доорх дампуурлын төрлүүдэд хамаарах гэрчлэгчээс шаардагдах дампуурлын тодорхойлолт авах хүсэлт гаргана.

Дампуурлын төрөл	Гэрчлэгч
Дампуурал	Дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч
Тусгай клиринг	Тооцоо хийгч
Иргэний дахин хөрөнгөжүүлэх	Дахин хөрөнгөжүүлэлтийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
Компанийн дахин хөрөнгөжүүлэх	Итгэмжлэгдсэн төлөөлөгч


- (2) Дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс тодорхойлолт олгох үед нөхөн төлбөр нэхэмжлэгч нь "立替払請求書" (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл) болон "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг) дээр шаардлагатай зүйлсийг бөглөж, тодорхойлолтын хамт (таслуулахгүйгээр) агентлаг руу илгээнэ үү.

- (3) Хэрэв дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл бусад гэрчилгээ олгогчоос нөхөн төлбөрийн хүсэлт гаргахад шаардагдах бүх эсвэл зарим хэсэгт тодорхойлолт авч чадаагүй бол нөхөн төлбөр нэхэмжлэгч нь тодорхойлолт авч чадаагүй асуудлаар Хөдөлмөрийн стандартын хяналтын газрын даргаас баталгаажуулах өргөдөл гаргаж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулах материал, баталгаажуулагчаас олгосон тодорхойлолтыг аван ойролцоо байгаа Хөдөлмөрийн стандартын хяналтын албанаас зөвлөгөө авна уу.



2 Бодит дампуурлын үед нэхэмжлэл гаргах журам

- (1) Нөхөн төлбөр нэхэмжлэгч нь Хөдөлмөрийн Стандарт хяналтын хэлтсийн даргад тухайн бизнес нь үйл ажиллагаагаа зогсоож дахин эхлүүлэх горьдлого тасарсан бөгөөд цалин хөлсний төлбөрийн чадваргүй болсныг тодорхойлох хүсэлт гаргана. Уг хүсэлт нь тухайн ажлаас гарсан нөхөн төлбөр нэхэмжлэгч ажилчид 2-оос дээш бөгөөд аль нэг нь баталгаажсан бол бусад ажлаас гарсан ажилчдад мөн хамаарна.
- (2) Хөдөлмөрийн Стандарт хяналтын хэлтсийн даргаас тодорхойлолт авсан бол нөхөн төлбөр нэхэмжлэгч нь эргээд уг даргаас нөхөн төлбөр нэхэмжлэхэд шаардлагатай зүйлсийг баталгаажуулах хүсэлт гаргана.
- (3) Хөдөлмөрийн Стандарт хяналтын хэлтсийн даргаас батламж бичиг авсан бол нөхөн төлбөр нэхэмжлэгч нь "立替払請求書" (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл) болон "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөж батламж бичигтэй хавсарган (таслуулахгүйгээр) агентлаг руу ирүүлнэ үү.



Далайчдын нөхөн төлбөрийг нэхэмжлэх журам

Далайчдын тухай хуулийн 1-р бүлэгт заасан далайчны хувьд "立替払請求書" (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл)-ийг илгээх газар нь Орон нутгийн зам тээврийн товчоо болох тул анхаарна уу.

1. Хууль ёсны дампуурлын хувьд

- (1) Нөхөн төлбөр нэхэмжлэгч нь итгэмжлэгдсэн төлөөлөгч зэрэг гэрч этгээдэд нөхөн төлбөрийн нэхэмжлэлд шаардагдах тодорхойлолт авах хүсэлт гаргах ба тодорхойлолтыг авсны дараа нэхэмжлэгч нь "立替払請求書" (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл) болон "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөж тодорхойлолттойгоо хамт хавсарган (таслуулахгүйгээр) Орон нутгийн зам тээврийн товчоонд илгээнэ үү.
- (2) Нөхөн төлбөрийн нэхэмжлэлд шаардлагатай бүгд ба зарим хэсэгт дампуурлын гэрчлэгчээс тодорхойлолт авч чадаагүй бол нөхөн төлбөр нэхэмжлэгч нь Орон нутгийн зам тээврийн товчоонд хандан тодорхойлолт авч чадаагүй зүйлсийн талаар баталгаажуулж өгөх хүсэлт гаргаж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл тодорхойлолт болон гэрчлэгчээс авсан бичиг баримтуудаа аваад өөрт ойрхон Орон нутгийн зам тээврийн товчоонд очиж зөвлөгөө авна уу.

2. Бодит дампуурлын хувьд

- (1) Нөхөн төлбөр нэхэмжлэгч нь Орон нутгийн зам тээврийн товчоонд далайчны үнэмлэхээ үзүүлэн тодорхойлолт авах хүсэлт гаргана. Тодорхойлолт авсан бол Орон нутгийн зам тээврийн товчоонд далайчны үнэмлэхээ үзүүлэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлд шаардлагатай зүйлсийн баталгаа авах хүсэлт гаргана.
- (2) Орон нутгийн тээврийн товчооны даргаас батламж бичиг авсан бол нөхөн төлбөр хүсэгч нь "立替払請求書" (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл) болон "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-д шаардлагатай хэсгийг бөглөж баталгаажуулалтын мэдэгдлийн хамт хавсарган (таслуулахгүйгээр) Орон нутгийн тээврийн товчоонд илгээнэ үү.

Ⅶ

Нөхөн төлбөр олгох

Агентлаг нь ирүүлсэн "未払賃金の立替払請求書" (Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийн нэхэмжлэл)-ийг шалгаж, төлбөрийг зөвшөөрсөн бол "Олгогдоогүй цалин хөлсийг нөхөн төлөх тухай шийдвэр / төлбөрийн мэдэгдэл" (үүнд ажлаас гарсан орлогоос татвар суутган тооцох маягт / тусгай татвар суутгах хуудас орно)-ийг нэхэмжлэгчид илгээх бөгөөд нөхөн төлбөрийг нэхэмжлэгчийн заасан нэхэмжлэгчийн нэр дээр энгийн харилцах данс руу шилжүүлнэ.

Мөн, нөхөн төлбөрийг ердийн цалин хөлс, ажлаас гарсны тэтгэмж хоёуланг нь Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн 29-4 дүгээр зүйлд заасны дагуу ажлаас гарах орлого гэж тооцож, бусад орлогоос тусад нь татвар ногдуулна. Гэхдээ ажлаас гарах орлогын хувьд доор харуулсны дагуу татвараас чөлөөлөхийг зөвшөөрдөг тул нөхөн төлбөрийн хүсэлтийн маягтын доод хэсэгт "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөсөн бол татвараас чөлөөлөгдөнө.

Ажилласан жил	Татвараас чөлөөлөгдөх дүн
20-иос доош	400,000 иен × ажилласан жил (800,000 иен хүрэхгүй бол 800,000 иен)
20-иос дээш	8 сая + 700,000 × (ажилласан жил – 20 жил)

Ⅷ

Шударга бусаар авсан бол

Хэрэв хууран мэхлэлт болон бусад залилангийн аргаар нөхөн төлбөр авсан болон бизнес эрхлэгч хам оролцон хуурамч тайлан, нотолгоо үйлдэж нөхөн төлбөрийг төлүүлсэн бол эдгээр үйлдлээр нөхөн төлбөрийг хүлээн авсан этгээд болон хамтран үйлдсэн этгээдэд залилангийн хэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Мөн, хууран мэхлэлт болон бусад хууль бус үйлдлээр нөхөн төлбөр авсан этгээд, үүнд оролцсон бизнес эрхлэгчдийн хувьд засгийн газраас нөхөн төлсөн мөнгөний буцаан олголт ба түүнтэй дүйцэх хэмжээний төлбөрийг (нугалж төлөх гэж нэрлэдэг) төлүүлэх болно.

1 Нэхэмжлэх эрхээ хэрэгжүүлэх

Нөхөн төлбөр хийх үед агентлаг нь Иргэний хуулийн 499 дүгээр зүйлд заасны дагуу нөхөн төлбөртэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр авсан ажилтны нэрийн өмнөөс цалингийн нэхэмжлэл гаргах эрхтэй болно. Агентлаг нь зээлийн менежментийн тухай эрх зүйн заалтуудын дагуу уг цалингийн нэхэмжлэлийг үндэслэн бизнес эрхлэгчээс нэхэмжилнэ.

Тодруулбал, хууль ёсны дампуурлын тухайд дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид тухайн сарын дотор нөхөн төлсөн мөнгөө нэгтгэн дараа сарын эхэнд төлөөлөх эрхтэй болсон тухай болон төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг мэдэгдэх бөгөөд дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шүүхэд гаргасан цалингийн нэхэмжлэлийн мэдэгдлийн хариуг авч, дараа сарын эцэс хүртэл хугацаанд Дампуурлын нэхэмжлэлийн мэдэгдэл эсвэл Дампуурлын нэхэмжлэгчийн нэрийг өөрчлөх мэдэгдлийг шүүхэд хүргүүлнэ.

Бодит дампуурлын хувьд, бизнес эрхлэгчид төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг дараа сарын эхээр тухайн сард нөхөн төлсөн мөнгөний хамт мэдэгдэж, цалин хөлсөө төлөх үүргээ биелүүлэхийг шаардана. Агентлагаас төлбөрийг нөхөн төлсөн нь бизнес эрхлэгч цалин хөлс төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

(1) Дампуурал / компани дахин хөрөнгөжүүлэх тохиолдолд

- а) Дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд цалин хөлсийг ажилчны өмнөөс нэхэмжлэх эрхээ авсан тухай мэдэгдэх
- б) Шүүхэд нэхэмжлэлийн мэдэгдэл эсвэл нэхэмжлэгчийн нэрийг өөрчлөх мэдэгдлийг гаргаж, дампуурлын бүртгэлийн ажилд оролцоно.
- в) Сангийн нэхэмжлэлийн төлбөрийг төлөх, давуу эрхтэй дампуурлын нэхэмжлэлийг барагдуулах

(2) Иргэний сэргээн босгох / тусгай клирингийн хувьд

- а) Сэргээн босголтын үүрэг гүйцэтгэгч (итгэмжлэгдсэн төлөөлөгч) эсвэл клиринг хийх этгээдэд цалингийн нэхэмжлэлийг төлөөлөн гүйцэтгэх эрхтэй болсноо мэдэгдэж, төлбөрөө нэхэмжлэх
- б) Сэргээн босголтын үүрэг гүйцэтгэгч (итгэмжлэгдсэн төлөөлөгч) эсвэл клиринг хийх этгээдээс өр төлбөрийг зөвшөөрсөн бичиг, эргэн төлөх төлөвлөгөө гаргуулах хүсэлт ба төлбөрийн нэхэмжлэл

(3) Бодитоор дампуурсан бол

- а) Бизнес эрхлэгчид олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийг мэдэгдэх, цалин хөлсний төлбөрийг барагдуулах нэхэмжлэл гаргах
- б) Өр барагдуулах ажиллагаа
- в) Шаардлагатай бол иргэний журмаар нэхэмжлэл гарган албадан хураах, түр хугацаагаар хураах, моргежийн нөхцөл зэрэг замаар цалин хөлс нэхэмжлэх эрхийг хэрэгжүүлэх

2 Нөхөн төлбөрийг барагдуулах тухай

Иргэний хуулийн 488 дугаар зүйл, агентлагийн үйл ажиллагааны журмын дагуу нөхөн төлбөрийг барагдуулах дараалал нь ажлаас гарах тэтгэмж, дараа нь тогтмол цалин хөлс байна. Тухайн үед өөр төлбөрийн хугацаатай тогтмол цалин хөлс байгаа бол эргэн төлөх хугацаа ирсэн дарааллын дагуу барагдуулна.

Дампуурлын бүртгэлийн явцад агентлагийн нөхөн төлбөр нь эргэн төлөлтийн ижил хугацаатай нэхэмжлэлийн хувьд ажилчны цалин хөлс нэхэмжлэх эрхтэй адил шинж чанартай байдаг тул практик дээр сангийн нэхэмжлэлийн хэсэг ба давуу эрхтэй дампуурлын нэхэмжлэлийн хэсгийн харьцаанд үндэслэн пропорцын дагуу зохицуулдаг.

Бөглөх удирдамж

- Хар өнгийн балаар гаргацтай бөглөнө.
- Хүрээнээс халихгүй байхаар бөглөх ба тоо дугааруудыг баруун талд шахаж бөглөнө.
- Өгөхөөсөө өмнө орхигдуулсан, буруу бичсэн зүйл байгаа эсэхийг дахин шалгана.
- Нэхэмжлэх эсвэл мэдүүлэгт орхигдсон зүйл зэрэг алдаа байвал бид тантай холбоо барьж баталгаажуулах тул нөхөн төлбөрийн хугацаа хойшилж болзошгүйг анхаарна уу.
- Нэхэмжлэх, мэдүүлгийн хуудсыг хэрхэн бөглөх талаар тодруулах зүйл байвал Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлагийн Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийн зөвлөгөө өгөх булан эсвэл ойролцоох Хөдөлмөрийн стандартын хяналтын газартай холбогдоно уу.

■ "未払賃金の立替払請求書" (Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийн нэхэмжлэл)-ийг бөглөх арга

独立行政法人 労働者健康安全機構理事長 殿		請求年月日		1	3
フリガナ		請求年月日		年	月
請求者	氏名	男・女		大正	昭和
	〒	〒		年	月
現住所		電話番号		日	日
立替払請求金額		円		拾	老

1| Эхлээд "Нэхэмжлэх огноо" -г бөглөнө үү.

Тухайн нэхэмжлэхийг агентлаг руу гаргах өдрийг бичнэ үү.

2| "Нэхэмжлэгчийн нэр" бичнэ үү.

- (1) Өрхийн бүртгэл дээрх нэрийг бичнэ үү. Гэрлэлт зэргээс шалтгаалан тодорхойлолт, батламж бичиг дээрх "Овог" өөрчлөгдсөн бол өрхийн бүртгэлийн хуулбар эсвэл иргэний бүртгэлийн бүрэн /хэсэгчилсэн хуулбарыг хавсаргана уу.
- (2) Катакана үсгээр бичих хэсгийг заавал бөглөх ба энэ нь энгийн харилцах дансны нэртэй ижил катакана байна.
- (3) Эр эм хүйсийг сонгохдоо дугуйлна уу.

3| "Төрсөн он сар өдөр" -ийг бичнэ үү.

Барууны (Григорийн календар) биш, Японы үндэсний он тооллоор бичнэ. Хамрагдах эриний нэрийг сонгож дугуйлаад эриний онын тоог бичнэ үү. Жишээ: 1977 онд төрсөн бол "Шова 52 он" гэж бичнэ.

4| "Одоогийн хаяг / утасны дугаар"-ыг бичнэ үү.

- (1) Одоо амьдарч буй хаягаа бичнэ үү. Мөн шуудангийн кодоо оруулахаа бүү мартаарай.
- (2) Одоогийн хаягаа дэлгэрэнгүй үнэн зөв бичнэ үү. Хороолол, байр, компанийн байр, түр буудал бол нэр, барилга, дугаар эсвэл буух газрын эзний овог нэрийг заавал оруулна уу.
- (3) Утасны дугаарын хувьд суурин утасны дугаар болон гар утастай бол тус тусыг оруулна уу.

5] "Нөхөн төлбөрийн нэхэмжлэх дүн"-г бөглөнө үү.

- (1) Нэхэмжлэлийн баруун талд байгаа "証明書" (Тодорхойлолт) эсвэл "確認通知書" (Баталгаажуулах мэдэгдэл) хэсгийн доод хүснэгтийн "Олгогдоогүй цалингийн нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолох" хэсэгт байх "Олгогдоогүй цалингийн нөхөн төлбөрийн хэмжээ" нүдэнд мөнгөн дүнг оруулна уу. Мөн, "Олгогдоогүй цалингийн нийт дүн ба дээд хязгаар"-ыг буруу оруулах тохиолдол байдаг ба энэ тохиолдолд нэхэмжлэгч үүнийг засах шаардлагатай бөгөөд нөхөн төлбөр хойшлох шалтгаан болохыг анхаарна уу.
- (2) Мөнгөн дүнг баруун талд шахаж оруулах ба тооны оронг шалгана уу. Хэрэв мөнгөн дүнгийн өмнө хоосон зай байвал "¥" тэмдэгт оруулна уу.

6] "Нөхөн төлбөр хүлээн авах санхүүгийн байгууллага"-г бөглөнө үү. (15-р хуудсанд байгаа бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг үзнэ үү)

- (1) Нэхэмжлэгчийн нэр дээрх ердийн харилцах дансыг заавал бөглөнө. (Нэхэмжлэгчээс өөр нэр дээрх дансанд мөнгө шилжүүлэх боломжгүй. Байгууллагын нэр, дэлгүүрийн нэр бүхий данс руу мөн шилжүүлэх боломжгүй).
 - (2) Нэхэмжлэгч хадгаламжийн дэвтрээ шалгаж, санхүүгийн байгууллагын нэр, салбарын нэр, салбарын дугаар, энгийн харилцах дансны дугаарыг зөв оруулна уу. Мөн банкны салбаруудад нэгтгэх ба цомхотгосноос болж салбарын нэр, дугаарт өөрчлөлт гарсан эсэхийг шалгана уу.
 - (3) Хэрэв Юүчо банкныг сонгосон бол шилжүүлэх салбарын нэр, салбарын дугаар, дансны дугаарыг оруулна уу. Мөн, хадгаламжийн дэвтрийн хуулбар (дэвтрийн ар талд байх шилжүүлэх салбарын нэр, салбарын дугаар, дансны дугаар бичигдсэн хэсэг)-ыг хавсаргана уу.
 - (4) Гадаадын иргэн бол буруу шилжүүлэг хийхээс сэргийлэн хадгаламжийн дэвтрийн хуулбар (дэвтрийн ар талд байх данс эзэмшигчийн нэр, дансны дугаар, салбарын дугаар бичигдсэн хэсэг)-г хавсаргана уу.
 - (5) Гадаад улсад мөнгө шилжүүлэхийг хүсвэл доорх бичиг баримтыг (A-C хүртэл бүгд) "未払賃金の立替払請求書" (Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийн нэхэмжлэл)-тэй хамт хавсаргаж илгээнэ үү.
 - A. "海外送金申請書" (Гадаад улсад мөнгө шилжүүлэх өргөдлийн маягт) (Маягтыг хэрхэн авах тухайг агентлагаас лавлана уу)
 - B. Биеийн байцаалт (a,b бүгд)
 - a. Оршин суух үнэмлэхийн хуулбар (ар өвөр тал)
 - b. Паспортын хуулбар (цээж зурагтай хуудас, Японоос гарсан, орсон өдөр бичигдсэн бүх хуудаснууд)
 - C. Шилжүүлэг хүлээн авах банкны хадгаламжийн дэвтрийн хуулбар (хэрэв дэвтэр байхгүй бол данс нээлгэсэн тухай баримт)
- *1 Шилжүүлгийн шимтгэл нь нөхөн төлбөрийн дүнгээс суутгагдана.
 *2 15-р хуудасны бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтын "Гадаадын иргэн нөхөн төлбөр нэхэмжлэх үед" хэсгийг үзнэ үү.

◎立替払金振込先金融機関の指定 (請求者本人名義の普通預金口座に限ります。)

金融機関名										(番号を○で囲んでください。) ① 銀行 ② ゆうちょ銀行(郵便局) ③ 信託銀行 ④ 信用金庫 ⑤ 信用組合 ⑥ 労働金庫 ⑦ 農業協同組合(漁業協同組合は利用できません。)
フリガナ										
本・支店(支所)名 (出張所)										
本・支店番号										(注意事項) 1 ゆうちょ銀行を指定される方は、振込用の店名・店番・口座番号を記入してください。 2 ゆうちょ銀行を指定される方は、通帳の写し(名義人・口座番号がわかる部分)を添付してください。 3 外国籍の方(日本語に不安がある方)は、誤振込防止のため、2と同様に通帳の写しを添付してください。
普通預金口座番号										
フリガナ										
口座名義人										

"未払賃金の立替払請求書" (Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийн нэхэмжлэл)-ийг бөглөх арга нь үүгээр дуусна.

■ Овог нэр, хаяг, шилжүүлэг хүлээн авах санхүүгийн байгууллагыг өөрчлөх

Хэрэв дампуурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн баталсан нэр, хаягт өөрчлөлт орсон, эсвэл шилжүүлэг хүлээн авах санхүүгийн байгууллагыг өөрчлөх бол баруун талд үзүүлсэн "Олгогдоогүй цалингийн нөхөн төлбөр нэхэмжлэгчийн овог нэр, хаяг, шилжүүлэг хүлээн авах санхүүгийн байгууллагыг өөрчлөх хүсэлт"-ийг манай вэбсайтаас татаж авч, шаардагдах зүйлсийг бөглөж, тус бүрд шаардлагатай бичиг баримтыг хавсарган ирүүлнэ үү. Утас, и-мэйлээр хүлээж авахгүй.

- *1 "Оршин суугаа газрын тодорхойлолтын хуулбар"-ыг ирүүлэхдээ гэр бүрийн бүртгэлт бүртгүүлсэн хаяг, хувийн дугаар (my number) бичигдээгүй материалыг ирүүлнэ үү. (Олгогдоогүй цалинг нөхөн төлөх системд ашиглагдахгүй)
- *2 15-р хуудасны бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг үзнэ үү.

令和 年 月 日

未払資金の立替払請求者の氏名・住所・振込先金融機関変更届
独立行政法人労働者職業安定機構理事長 届

届出者
電話
氏名

下記の上より氏名・住所・振込先金融機関を変更するの届け出ます。

立替払請求書の
の生年月日 年 月 日 性別 住所

○氏名を変更した場合は

氏名 (フリガナ)	変更後の氏名
フリガナ	
変更前の氏名	
氏名	変更の理由

※ 変更理由に「転居」、「結婚」、「再婚」、「結婚・再婚・再婚」のいずれかを選択してください。

○住所を変更した場合は

届出者 の住所	電話番号
〒	
都・道 府・県	市・区 町・村
番	号

※ 住所変更は「転居」、「結婚」、「再婚」、「結婚・再婚・再婚」のいずれかを選択してください。

○振込先金融機関を変更する場合は

振込先 の名称	(銀行・信託・信託)
支店 の名称	(本店・支店・支所・出張所)
支店 番号	
支店 名称	
支店 名称	

※ 変更理由に「転居」、「結婚」、「再婚」、「結婚・再婚・再婚」のいずれかを選択してください。

※ 変更理由に「転居」、「結婚」、「再婚」、「結婚・再婚・再婚」のいずれかを選択してください。

■ "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийн тухай

Нөхөн төлбөрийг тогтмол цалин хөлс, ажлаас гарах тэтгэмж хоёуланг нь Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн 29-4 дүгээр зүйлд заасны дагуу ажлаас гарах орлого гэж тооцож, бусад орлогоос тусад нь татвар ногдуулна.

Гэхдээ ажлаас гарах орлогын хувьд доор харуулсны дагуу ажлаас гарах орлогын татварын хөнгөлөлттэй тул нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн хүсэлтийн маягтын доод хэсэгт "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг) дээр тэмдэглэл хийсэн бол татвараас хөнгөлөлтөд хамрагдана. Иймд, "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөх шаардлагатай гэсэн үг. Хүсэлт ирүүлээгүй (тэмдэглэлгүй) бол нөхөн төлбөрөөс 20 хувьтай тэнцэх хэмжээний орлогын албан татвар суутгагдахыг анхаарна уу.

Хэрэв нөхөн төлбөрөөс өөр бусад тэтгэврийн тэтгэмж авч байгаа (Жижиг, дунд ААН-ийн ажлаас гарах хамтарсан тэтгэмж зэрэг гаднаас санхүүждэг ажлаас гарах тэтгэмж авч байгаа) бол нэхэмжлэхийн доод нүдэнд байгаа "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг) биш татварын албанд гаргадаг (татварын товчооноос авах эсвэл Татварын ерөнхий газар болон Агентлагийн веб хуудаснаас татаж авах боломжтой) "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийн маягт болон тухайн ажлаас гарах орлогын "退職所得の源泉徴収票・特別徴収票" (Ажлаас гарах орлогын эх үүсвэрээс суутгалын хуудас/тусгай суутгалын хуудас)-ны хуулбарыг ирүүлэх шаардлагатай.

Дээрх мэдэгдлүүд нь нэрийн дагуу зөвхөн ажлаас гарах тэтгэмжид хамааралтай мэт боловч (зарим нь тогтмол цалингийн нөхөн төлбөрт хамаарагдахгүй гэж андуурдаг), ажлаас гарах тэтгэмжийн үлдэгдэл байхгүй бөгөөд зөвхөн олгогдоогүй тогтмол цалин байгаа тохиолдолд мөн заавал бөглөж ирүүлнэ үү.

- *1. Хувийн дугаар (my number) нь олгогдоогүй цалингийн нөхөн төлбөр олгох хөтөлбөрт ашиглагдахгүй тул бөглөх шаардлагагүй.
- *2 15-р хуудасны бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг үзнэ үү.

■ "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөх заавар

1| "Ажлаас гарсан жил" бичнэ.

"Он жил" нүдэнд нэхэмжлэгч этгээдийн ажлаас гарсан жилийг бичнэ.
Жишээ) 2020 оны 4-р сард ажлаас гарсан бол "2" гэж бичнэ.

川崎北税務署長殿 市町村長殿	年分	退職所得の受給に関する申告書・退職所得申告書	提出日	上記立替払請求書記載請求年月日のとおり
-------------------	----	------------------------	-----	---------------------

2| "Овог нэр" бичнэ.

Нэхэмжлэгчийн овог нэрийг бичнэ үү.

川崎北税務署長殿 市町村長殿	年分	退職所得の受給に関する申告書・退職所得申告書	提出日	上記立替払請求書記載請求年月日のとおり			
氏名		退職年月日	年	月	日		
退職した年の1月1日現在の住所		あなたが退職した会社における勤続期間	自	年	月	日	年
現住所	上記立替払請求書記載のとおり		障害者になったことにより退職した事実の有無	有・無			
非居住者の方は国籍名を記入		入国年月日	年	月	日		
退職所得の支払者の住所及び名称	所在地	神奈川県川崎市中原区木月住吉町1番1号	名称	独立行政法人 労働者健康安全機構			

3| "Ажлаас гарсан жилийн 1-р сарын 1-ний өдрийн байдлаар байгаа хаяг" -ыг бичнэ.

Нэхэмжлэгч ажлаас гарсан жилийн 1-р сарын байдлаар оршин суугаа хаягаа оруулна уу.

Жишээ: Ажлаас гарсан жил нь 2020 он бол, 2020 оны 1-р сарын 1-нд оршин сууж байсан хаягийг бичнэ. (Оршин суух бүртгэлд хамрагдсан хаяг)

川崎北税務署長殿 市町村長殿	年分	退職所得の受給に関する申告書・退職所得申告書	提出日	上記立替払請求書記載請求年月日のとおり			
氏名		退職年月日	年	月	日		
退職した年の1月1日現在の住所		あなたが退職した会社における勤続期間	自	年	月	日	年
現住所	上記立替払請求書記載のとおり		障害者になったことにより退職した事実の有無	有・無			
非居住者の方は国籍名を記入		入国年月日	年	月	日		
退職所得の支払者の住所及び名称	所在地	神奈川県川崎市中原区木月住吉町1番1号	名称	独立行政法人 労働者健康安全機構			

4| "Ажлаас гарсан огноо", "Ажлаас гарсан компанид ажилласан хугацаа"-г бичнэ.

Нэхэмжлэгчийн тухайн компаниас гарсан огноо болон ажилласан хугацааг бичихдээ тодорхойлолт болон баталгаажуулах мэдэгдэлд бичигдсэн "Ажилд орсон огноо" болон "ажлаас гарсныг тодорхойлох өдөр"-г шалгана уу.

Мөн, "Хэзээ ажилд орсон" болон "Хэзээ ажлаас гарсан" хэсэгт тодорхойлолт болон баталгаажуулах мэдэгдэлд бичсэн ажилд орсон ба гарсан өдөртэй ижил бичих ёстой.

Ажилласан хугацаанд 1 жилээс доош бутархай тоо байвал бүхэл болгож бичнэ үү.

Жишээ: Ажилласан хугацаа 20 жил 12 хоног бол 21 жил гэж бичнэ.

提出日	上記立替払請求書記載請求年月日のとおり			「証明書」又は「確認通知書」	
退職年月日	年	月	日	雇入年月日	年 月 日
あなたが退職した会社における勤続期間	自	年 月 日	年	⑤ 基準退職日	年 月 日
	至	年 月 日	※1年未満の勤続は 切り上げる。		
障害者になったことにより退職した事実の有無	有・無				
入国年月日	年	月	日		

5| “Хөгжлийн бэрхшээлтэй болсноос шалтгаалан ажлаас гарсан эсэх”-ийг бөглөнө.

Дампуурлын улмаас ажлаас гарсан тул “үгүй”-г дугуйлна уу.

障害者になったことにより退職した事実の有無	有・ <input checked="" type="radio"/> 無
-----------------------	---------------------------------------

6| Хэрэв та гадаадын иргэн бол “Иргэншил” болон “Японд ирсэн он сар өдөр”-ийг бөглөж, дараах бичгүүдийг гаргана.

非居住者の方は 国籍名を記入	入国年月日	年	月	日
-------------------	-------	---	---	---

Хэрэв та гадаадын иргэн бол Япон улсын татварын систем танд хэрэгжиж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс болон шилжүүлгийг үнэн зөв хийхийн тулд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ үү. 【Шаардлагатай материалууд (A-C бүгд)】

- A. Оршин суух үнэмлэхийн хуулбар (ар өвөр)
- B. Паспортын хуулбар (“Цээж зурагтай хуудас” ба “Японд ирсэн гарсан өдөр бичигдсэн бүх хуудас”)
- C. Хадгаламжийн дэвтрийн хуулбар ”нүүр хуудасны ар тал (данс эзэмшигчийн нэр, дансны дугаар, салбарын нэр зэрэг бичигдсэн хэсэг)”

Дээрх шаардлага бүхий A, B баримт бичгүүдээс дараах “Японд оршин сууж амьдрах шаардлага”-ыг хангасан болохыг баталж чадах бол ажлаас гарсан орлогын татварын хөнгөлөлт авах боломжтой болох ба ихэнх хүн татвараас чөлөөлөгдөнө. (Нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн дүн, ажилласан жилээс хамаарч татвар ногдуулж болно.)

Японд оршин сууж амьдрах шаардлага (ажлаас гарсныг тодорхойлох өдөр хүртэл)

- ① 1 жилээс дээш хугацаагаар Японд байнгын ба түр хаягтай байх
- ② Японд оршин суудаг байх

Хэрэв шаардлагыг хангасан болохыг баталгаажуулах боломжгүй тохиолдолд оршин суугч бус гэж үзэн орлогын албан татвар, нөхөн сэргээлтийн тусгай орлогын албан татвар (20 хувьтай тэнцэх хэмжээ) ногдуулах болно.

*1 “Давхар татварын гэрээ” ний хувьд тусдаа бүрдүүлэлт шаардлагатай.

*2 15-р хуудасны бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтын “Гадаадын иргэн нөхөн төлбөр нэхэмжлэх үед” хэсгийг үзнэ үү.

*Ажилчин нас барсан бол

Хэрэв ажилчин нас барсан бол түүний өв залгамжлагч нь төлөөлөн нэхэмжлэгч байна. Иймд “立替払請求書” (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл)-ийн нэхэмжлэгчийн хэсэг, шилжүүлэг хүлээн авах санхүүгийн байгууллагын хэсэгт өв залгамжлагчийн овог нэр, төрсөн огноо, хаяг, шилжүүлэг хүлээн авах санхүүгийн байгууллагын нэр зэргийг оруулна уу. “退職所得の受給に関する申告書・退職所得申告書” (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөх шаардлагагүй.

Хэрэв олон өв залгамжлагчид байгаа бол нэг төлөөлөгч нэхэмжлэл гаргах шаардлагатай болох тул “代表者選任届出” (Төлөөлөн нэхэмжлэгч томилсон мэдэгдэл) болон нэхэмжлэгч нь нас барсан ажилчны өв залгамжлагч болохыг баталсан иргэний бүртгэлийн хуулбар, төлөөлөн нэхэмжлэгч томилсон мэдэгдэлд гарын үсэг зурсан бусад өв залгамжлагчийн дардасны тодорхойлолтыг хавсаргана уу.

I	Орлодоггүй цагил хөлийг нөхөн төлбөр өгөх
II	Нөхөн төлбөр авах боломжтой хүмүүс
III	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжтой хугацаа
IV	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах боломжтой хугацаа
V	Нөхөн төлбөрдөх мөнгөн дүн
VI	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах бүрдүүлэлт
VII	Нөхөн төлбөр олгох
VIII	Шударга бусаар авсан бол
IX	Нөхөн төлбөрийг нэхэмжлэх
X	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах үед шаардлагатай бол

労働者健康安全機構送付用	機構整理番号
--------------	--------

(未払賃金の立替払事業) 様式 第 8 号
未払賃金の立替払請求書

賃金の支払の確保等に関する法律第7条の規定に基づき、次のとおり未払賃金の立替払を請求します。

独立行政法人 労働者健康安全機構理事長 殿	請求年月日	令和2年 9月 1日
フリガナ ケンコウ タロウ	性別	男
氏名 健康 太郎	生 年 月 日	大正昭和平成令和 52年 7月 1日
〒 2 1 1 - 0 0 2 1	神奈川県川崎市中原区木月住吉町1番1号	
現住所	健康安全マンション2号室	
立替払請求金額	電話番号	
1 5 6 8 0 0 0 円	(044) 431 - 8663	

◎立替払金振込先金融機関の指定（請求者本人名義の普通預金口座に限りです。）

金融機関名	健康	(番号を○で囲んでください。)	
フリガナ	アンゼン	① 銀行 ② ゆうちょ銀行(郵便局) ③ 信託銀行	
本・支店(支所)名(出張所)	安全	④ 信用金庫 ⑤ 信用組合 ⑥ 労働金庫	
本・支店番号	1 2 3	⑦ 農業協同組合(漁業協同組合は利用できません。)	
普通預金口座番号	1 2 3 4 5 6 7	(注意事項)	
フリガナ	ケンコウ タロウ	1 ゆうちょ銀行を指定される方は、振込用の店名・店番・口座番号を記入してください。	
口座名義人	健康 太郎	2 ゆうちょ銀行を指定される方は、通帳の写し(名義人・口座番号がわかる部分)を添付してください。	
		3 外国籍の方(日本語に不安がある方)は、誤振込防止のため、2と同様に通帳の写しを添付してください。	

川崎北税務署長殿 市町村長殿 2年分 退職所得の受給に関する申告書・退職所得申告書

氏名	健康 太郎	提出日	上記立替払請求書記載請求年月日のとおり
退職した年の1月1日現在の住所	〒031-0822 青森県八戸市白銀町7丁目7-7	退職年月日	令和2年 4月 12日
現住所	上記立替払請求書記載のとおり	あなたが退職した会社における勤続期間	自平成12年 4月 1日 21年 至令和2年 4月 12日
非居住者の方は国籍名を記入		障害者になったことにより退職した事実の有無	有・無
退職所得の支払者の住所及び名称	所在地 神奈川県川崎市中原区木月住吉町1番1号	国籍名	年 月 日
		名称	独立行政法人 労働者健康安全機構

- この立替払金のほかに、前に退職手当等の支払を受けたことがある方は、この申告書には記入しないで、税務署に備え付けてある「退職所得の受給に関する申告書(以下「税務署備付申告書」)」に必要事項を記載のうえ提出してください。また、本年中に他に退職手当等の支払を受けたことがある方は、「税務署備付申告書」に支払者が交付した「退職所得の源泉徴収票」を添付して提出してください。
- 1以外の方は、必ず上欄の申告書(太枠欄)に記入してください。
なお、非居住者(次のいずれかに該当する人。ア 日本国内に住所も居所も有しない人。イ 日本国内に住所がなく、かつ、日本国内に引き続き居所を有している期間が1年に満たない人。)の方は、所得税法及び租税条約に基づく課税となりますので、上欄の申告書に国籍名、入国年月日を記入してください。
- 上欄の申告書に記入がない場合又は「税務署備付申告書」の提出がない場合は、支払金額の20.42%相当額が退職所得に係る源泉徴収税額となります。

(注意) 立替払の請求ができる期間は、倒産については、裁判所の決定があった日の翌日から起算して二年間です。労働基準監督署長の認定があった日又は破産特別清算

※ 現住所は、番地まで正確に書いてください。住宅団地・アパート・マンション・社宅・宿舍又は寄宿の場合は、その名称・棟・号又は寄宿先の氏名を必ず書いてください。

■ Нөхөн төлбөрийн нэхэмжлэлд нэхэмжлэл гаргах, тодорхойлолт бүрдүүлэх арга

"立替払請求書" (Нөхөн төлбөрийн нэхэмжлэл) болон "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөсөн бол бүрдүүлэх материал ба хавсралт материалуудын хамт тодорхойлолт болон баталгаажуулсан мэдэгдлийг хамтад (таслуулахгүйгээр) ирүүлнэ үү.

<Ирүүлэх хаяг>

1-1 Kizukisumiyoshi-cho, Nakahara-ku, Kawasaki-shi, Kanagawa (ZIP: 211-0021)

Japan Organization of Occupational Health and Safety, Occupational Health and Wage Support Department, Examination Division

<Анхааруулга>

Нөхөн төлбөрийн шилжүүлэг хүлээн авах санхүүгийн байгууллагын нэр, салбарын нэр, салбарын дугаар, харилцах дансны дугаар алдаатай, "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөөгүй тохиолдолд агентлагийн зүгээс дахин лавлах шаардлага гарч нөхөн төлбөрийн явц удаашрах тул материал ирүүлэхээс өмнө сайн шалгана уу.

■ Нөхөн төлбөрийн нэхэмжлэлд шаардагдах бичиг баримтын жагсаалт

Бүрдүүлэх шаардлагатай материал	Бүрдүүлэх материал	Хавсралт материал	Анхаарах
Нөхөн төлбөр нэхэмжлэх бол	(Нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн доор байх) "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг) (11-р хуудас)	—	<ul style="list-style-type: none"> Нөхөн төлбөрийг Татварын тусгай арга хэмжээний тухай хуулийн дагуу ажлаас гарсан орлого гэж тооцдог. Мэдүүлгийн хуудсыг заавал бөглөж бичнэ үү. Бөглөөгүй бол нөхөн төлбөрийн дүнгийн 20 хувийг суутган авна.
Өөр ажлаас гарсан орлого байгаа бол (жижиг дунд ААН-н ажлаас гарсан тэтгэмжийг хамтран төлөх хөтөлбөр зэрэг)	(Татварын албанаас маягт авдаг) "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг) (11-р хуудас)	Тухайн ажлаас гарсан орлогоос татварын урьдчилан суутгасан тодорхойлолтын хуулбар	<ul style="list-style-type: none"> Мэдэгдэх хуудсыг Татварын үндэсний газар эсвэл агентлагийн вэбсайтаас татаж авах боломжтой. Хувийн дугаар (my number) оруулах шаардлагагүй.
Шилжүүлэг хүлээн авагч нь Юүчо банк бол (10-р хуудас харах)	—	Хадгаламжийн дэвтрийн хуулбар	Хадгаламжийн дэвтрийн нүүр хуудасны арын хэсгийн хуулбар (бусад банк руу шилжүүлэхэд ашигладаг салбарын нэр, дугаар, дансны дугаар бичигдсэн хэсэг).
Гадаадын иргэн нөхөн төлбөр нэхэмжлэх тохиолдолд (10,13-р хуудас харах)	Нөхөн төлбөрийн нэхэмжлэл	<ul style="list-style-type: none"> Хадгаламжийн дэвтрийн хуулбар Оршин суух үнэмлэх (ар өвөр) ба паспортын хуулбар 	<ul style="list-style-type: none"> Хадгаламжийн дэвтрийн нүүр хуудасны арын хэсгийн (салбарын нэр, дугаар, дансны дугаар, данс эзэмшигчийн нэр бичигдсэн хэсэг) хуулбар. Паспортын хуулбар ("Цээж зурагтай хуудас" ба "Японд ирсэн гарсан дардастай бүх хуудас") (13-р хуудас 6) Гадаад руу мөнгө илгээх бол "海外送金申請書" (Гадаадад мөнгө шилжүүлэх хүсэлт) гаргах шаардлагатай тул бидэнтэй холбоо барина уу. (10-р хуудсыг үзнэ үү 6 (5)) Нийтлэг нэрээр нэхэмжлэх бол тусдаа баримт бичиг шаардагдана. (Тухайн хүн хавсаргасан баримт бичигт байгаа нэртэй ижил хүн болохыг заасан баримт бичгийн хуулбар.)
Овог нэр өөрчлөгдсөн бол	—	Өрхийн бүртгэлийн хуулбар эсвэл түүний хэсэгчилсэн хуулбар	Овог нэр өөрчлөгдсөн нь мэдэгдэх хэсгийн хуулбар
Оршин суух хаяг өөрчлөгдсөн бол	Олгодоогүй цалингийн нөхөн төлбөр нэхэмжлэгчийн овог нэр, хаяг, банкны өөрчлөлт мэдэгдэх (11-р хуудас)	Жолооны үнэмлэхийн хуулбар (ар өвөр), оршин суугчийн үнэмлэхийн хуулбар гэх мэт.	Гэрийн хаяг, хувийн дугаар (my number) бичигдээгүй оршин суух үнэмлэхийн хуулбараа ирүүлнэ үү.
Шилжүүлэг хүлээн авах санхүүгийн байгууллага өөрчлөгдсөн бол	—	Өөрчлөгдөх банкны хадгаламжийн дэвтрийн хуулбар	Шилжүүлэг хүлээн авах банкны дэвтрийн нүүр хуудасны арын хэсэг (банкны нэр, салбарын нэр, дансны дугаар, эзэмшигчийн нэр г.м-ийг заасан хэсэг) -н хуулбар
Ажилчин нас барсан бол (13-р хуудас)	Төлөөлөгч томилсон мэдэгдэл	<ul style="list-style-type: none"> Ажлаас гарсан ажилчин нас барсан, нэхэмжлэгч нь өв залгамжлагч болохыг баталсан өрхийн бүртгэлийн хуулбар Төлөөлөгч томилох мэдэгдэл гарын үсэг зурсан бүх өв залгамжлагчдын дардасны гэрчилгээ 	<ul style="list-style-type: none"> Нэхэмжлэгч нь өв залгамжлагч байна. Нөхөн төлбөрийн хүсэлтийн маягтын доод нүдний "退職所得の受給に関する申告書・退職所得申告書" (Ажлаас гарах орлого хүлээн авах мэдүүлэг / ажлаас гарах орлогын мэдүүлэг)-ийг бөглөх шаардлагагүй.

*Бүрдүүлэх баримт бичгийн маягыг агентлагийн вэбсайтаас татаж авах боломжтой.

Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийн тухай зөвлөгөө өгөх булан

Доорх нөхөн төлбөрийн талаар ерөнхий мэдээллийг биеэр ирэх ба утсаар лавлана уу.

- Дампууралтай холбоотой төлөгдөөгүй цалингийн талаар
- Олгогдоогүй цалингийн нөхөн төлбөрийн талаар
- Нэхэмжлэл гаргах дэс дараалал
- Нэхэмжлэл бичих арга
- Нэхэмжлэлд бүрдүүлэх материал хавсралтууд
- Овог нэр, хаяг, банкны мэдээлэл өөрчлөх
- Тодорхойлолт бичих арга

Зарчмын хувьд, нэхэмжлэгчийн нөхөн төлбөрийн талаарх лавлагааг зөвхөн тухайн хүнээр хязгаарлах бөгөөд биеийн байцаалт шалгана. Мөн, төлбөр төлөлтийн тодорхой хугацаатай холбоотой асуултад хариулахгүйг анхаарна уу.

* Төлбөр хийгдэх хугацааг цалингийн нөхөн төлбөрийг төлөх мэдэгдэл (шуудангаар) -р мэдэгдэнэ.

Утас 044-431-8663

Ажиллах цаг Ажлын өдрүүдэд 9:15 -17:00

Эрүүл Мэнд Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамны Гадаад ажилчдад зориулсан зөвлөгөө өгөх тусгай дугаар

<https://www.check-roudou.mhlw.go.jp/soudan/foreigner.html>

Энэ нь ажлын нөхцөлийн талаар гадаад хэлээр утсаар зөвлөгөө авах боломжтой цонх юм.




1-1 Kizukisumiyoshi-cho,
Nakahara-ku, Kawasaki-shi,
Kanagawa
(ZIP:211-0021)

Утас: 044-431-8662

URL <https://www.johas.go.jp>

Бие даасан захиргааны нэгж Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын агентлаг Цалин хөлсний дэмжлэг, хяналтын хэлтэс



R3.4